



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/170

Алтай хот

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн  
бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалт, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэл, Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн "Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай" А/57/48 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөрт багтаан зохион байгуулсугай.

2.Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

3.1.Сумдын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хоршоо, иргэдэд бүртгэлтэй "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулах, ажлын хэсгийг орон нутагт ажиллах нөхцөл боломжоор хангах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрд гарган өгч хамтран зохион байгуулах;

3.2.Сумын салбар комиссыг сумын Засаг даргын орлогчоор ахлуулж, сумын татварын улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багийн Засаг дарга нарыг комиссын бүрэлдэхүүнд ажиллуулан үр дүнг холбогдох байгууллагад заасан хугацаанд мэдээлж ажиллах;

Аймгийн Засаг даргын 20<sup>25</sup> оны 05  
дугаар сарын 31-ны өдрийн 1170 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
БҮРТГЭЛ, ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: -(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд

- (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- (Цагдаагийн газрын дарга)
- (Татварын хэлтсийн дарга)
- (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
- (Орон нутгийн өмчийн газрын дарга)
- (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)
- (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын байцаагч)
- (Автотээврийн төвийн Автотээврийн хяналтын мэргэжилтэн)
- (Автотээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн)
- (Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга:-(Автотээврийн төвийн дарга)

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны 05  
дугаар сарын 31-ны өдрийн А/170 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
БҮРТГЭЛ, ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ Д/С 10942  
АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль болон "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулахад оршино.

Дараах шийдвэрүүдийг удирдлага болгоно. Үүнд:

- 1.Авто тээврийн тухай хууль
- 2.Авто замын тухай хууль
- 3.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
- 4.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- 5.Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэл
- 6.Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн "Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай" А/57/48 дугаар тушаал
- 7."Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналт үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийн жагсаалт
- 8.Салбарын бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт

Сумдад хамрагдвал зохих тээврийн хэрэгслийн тоо:

№	Сумдын нэр	Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо	Шинэчилсэн бүртгэл, тооллогод хамрагдах тээврийн хэрэгслийн тоо
1	Алтай	447	118
2	Баян-Уул	718	219
3	Бигэр	626	222
4	Бугат	495	149
5	Гуулин	31	7
6	Дарив	463	145
7	Дэлгэр	817	263
8	Есөнбулаг	5755	1621
9	Жаргалан	491	218
10	Тайшир	441	146
11	Тонхил	492	118
12	Төгрөг	499	115
13	Халиун	717	265
14	Хөхморьт	396	106
15	Цогт	685	189
16	Цээл	526	130
17	Чандмань	506	158
18	Шарга	561	202
19	Эрдэнэ	452	132
	Нийт	15118	4505

2.

Сумдад ажиллах үйл ажиллагааны ерөнхий чиглэл

Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн бүртгэл, мэдээллийн үндэслэн тухай сумд бүртгэлтэй 1-4 жил Техникийн хяналт үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцож байгаа эсэхийг үл харгалзан байгаа шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, хөдөлгүүрийн мэдээллийг холбогдох цахим систем (апликэйшин)-д заасан үзүүлэлт тус бүрээр баталгаажуулан авч шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулан сан үүсгэх, холбогдох хууль, журмын дагуу төлбөл зохих татвар, журмыг төлүүлэх, ашиглалтын шаардлагад нийцэхгүй болсон тээврийн хэрэгслүүдийг мэргэжлийн байгууллагад хандан хасалт хийлгэхэд оршино.

Говь-Алтай аймгийн Автотээврийн төв:

Шинэчилсэн бүртгэл, тооллогод хамрагдвал зохих тээврийн хэрэгслийн судалгааг сум, багаар хамтран ажиллах байгууллагуудад хүргүүлэх, Шинэчилсэн бүртгэл, тооллогод хамрагдсан тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг нэгтгэх, тайлагнах,

Татварын хэлтэс:

Тээврийн хэрэгсэл нь зарсан боловч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй, цаашид ашиглах боломжгүй болсон боловч албан ёсны хасалт хийгээгүй, олон жилийн хуримтлагдсан өртэй тээврийн хэрэгсэл эзэмшигчидтэй биечлэн болон утсаар холбогдож, өрийн мэдээлэл, төлөх боломжуудыг танилцуулан тэмдэглэл хөтлөх,

Татварын өрийг барагдуулан орон нутгийн төсөвт төвлөрүүлэх,

Цагдаагийн газар:

Гэмт хэрэг зөрчилд холбогдсон, журамлагдсан, саатуулагдсан тээврийн хэрэгслүүдийг тооллогод хамруулахад ажлыг зохион байгуулах,

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэлд тусгагдсан үүрэг чиглэлийн дагуу сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналт үзлэгт хамрагдаагүй, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангаагүй /төлбөрөө төлөөгүй/, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг авто замын хөдөлгөөнд оролцохыг хориглох,

Сумдын Цагдаагийн Тасгийн дарга, байцаагч, төлөөлөгч нарыг удирдамжид заасан байгууллагын чиг үүргийн дагуу ажиллуулах, тусгайлан үүрэгжүүлэх, ажлын явц гүйцэтгэлд өдөр тутмын хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах,

Орон нутгийн өмчийн газар:

Төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулах,

Төрийн өмчийн хорооны шийдвэрээр шилжилт хөдөлгөөн болон хасалт хийгдээгүйгээс болж өр үүсэж бүртгэл дээрээ тээврийн хэрэгслүүдийн баримт бичгийг бүрдүүлж бүртгэлээс хасуулах, шилжүүлэх, үүссэн өр төлбөрийг барагдуулах,

Төсөвт байгууллагуудын тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг шинэчлэн, ОНӨГ-ын бүртгэлийн АТТ-ийн бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах, татварын өртэй болж бүрэн төлж барагдуулах,

3.

Жагсаалтад тусгагдсан тээврийн хэрэгслүүдийн эзэмшигчдийг баг тус бүрээр хуваарь гарган тухайн багийн Засаг дарга нарт хариуцуулан газар дээр нь хянаж шалгах нөхцөл боломжоор хангах,

Сумдын Засаг дарга Тамгын газар:

Сумын хэмжээнд бүртгэлтэй жагсаалтад тусгагдсан тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогод бүрэн хамруулах чиг үүрэг бүхий комиссын бүрэлдэхүүнийг томилон /захирамж гаргах/ ажиллуулах,

Орон нутгийн төсөвт байгууллагуудад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг бүртгэл, тооллогод хамруулан мэдээллийг шинэчлэн /мэргэжлийн байгууллагын бүртгэл мэдээлэлтэй тулгах/, татварын өртэй бол бүрэн төлж барагдуулах,

Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн бүртгэл, мэдээллийг үндэслэн тухайн суманд бүртгэлтэй 1-4 жил техникийн хяналт үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцож байгаа эсэхийг үл харгалзан байгаа байршил дээр нь шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, хөдөлгүүрийн мэдээллийг холбогдох цахим систем /апликайшин/-д заасан үзүүлэлт тус бүрээр баталгаажуулан авч шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулах,

Багийн Засаг дарга нар

Жагсаалтад тусгагдсан тухайн багийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нэр дээр бүртгэлтэй, эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүдийн байршил, мэдээллийг урьдчилан бэлтгэж ажлын хэсгийн мэдээллээр хангах,

Тухайн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нэр дээр бүртгэлтэй, эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулах,

Иргэдэд тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогын талаарх мэдээ, мэдээллийг урьдчилан хүргэх,


Багийн Засаг дарга нь багт харъяалагдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нэр дээр бүртгэлтэй, эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн гаргах, бүртгэлээс хасах шаардлагатай тээврийн хэрэгслүүдийн холбогдох баримт материалыг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүргүүлэх,

Хугацаа

2023 оны 03 дүгээр сарын 30-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр,

Сумдад ажилласан ажлын тайлан нэгтгэн танилцуулах:

Ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу чиг үүрэгт ажлын явц, гүйцэтгэлийг аймгийн Засаг даргад танилцуулж, гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, сумдад хүргүүлэх,



2.

4. Ажлын хэсэг (Г.Чинбат)-т даалгах нь:

4.1. Аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани, аж ахуйн нэгжүүдийн автотээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслүүдийн бүртгэлийг аймагт салбар төлөөлөгчийн газрыг байгуулан нэр дээр нь шилжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

4.2. Сүүлийн 4 жил бүртгүүлээгүй, үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг хууль тогтоомжийн дагуу бүртгэлээс хасаж, татвар төлөгчдийн үнэн бодит тоо, бааз суурийг бэлэн болгох;

4.3. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг холбогдох хууль, журам, тушаал, зөвлөмжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулан дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлд тайлагнаж ажиллах;

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР